

НИЙГМИЙН АЖИЛТНЫ МӨРДВӨЛ ЗОХИХ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 21 ЗАРЧИМ

Ч.Байгалмаа, Т.Булганзаяа

1. Нийгмийн ажилтан мэргэжлийнхээ үйл ажиллагааг явуулах ёстой.

Бид бүгд багш нар хичээл зааж, эмч нар хүнийг эмчилж, нийгмийн ажилтнууд нийгмийн ажлын мэргэжлийн хил хязгаарын хүрээнд хүнд тусламж үйлчилгээ үзүүлдэг гэж боддог. Гэвч ямар ч мэргэжлийн хүмүүс өөр салбарын мэргэжлийн хүрээ рүү орж өөрсдийн үйл ажиллагаагаа өргөтгөх нь нийтлэг ажиглагддаг. Нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн энэ зарчим нь нийгмийн ажилтнууд юу хийхээр бэлтгэгдэж, юу хийх зөвшөөрөлтэй түүнийг л хийхийг сануулсан үг юм.

Нийгмийн ажил нь нийгмийн үйл ажиллагаанд голлон анхаарч, хүмүүс болон тэдний хүрээлэн буй орчин хоорондын харилцан үйлдлийг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Хүмүүс, тэдний хүрээлэн буй орчны хоорондын харилцан үйлдэл, уялдаа холбоо, нөхцөл байдлыг ойлгож ажиллах мэдлэг, үнэт зүйлс, ур чадвартай боловсон хүчнийг тус мэргэжил шаарддаг. Нийгмийн ажилтнууд өөр салбарын мэргэжилтний үйл ажиллагааг тухайлбал, сэтгэцийн эмчийн үйл ажиллагааг явуулах ёсгүй юм.

Хэдийгээр өөр өөрсдийн мэргэжлийн хил хязгаарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг ч зарим үйл ажиллагааны давхацлын улмаас шинжлэх ухааны салбаруудын дунд тодорхой мэргэжлийн үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээтэй холбоотой тулгамдсан асуудал нилээдгүй байдаг. Энэ асуудал нь нэг шинжлэх ухааны мэргэжилтэн өөр шинжлэх ухааны үйл ажиллагаа руу орж түүнийг гүйцэтгэх үед маш тодорхой гарч ирдэг. Нийгмийн ажлын ёс зүйн хэм хэмжээнд зааснаар нийгмийн ажилтны үйл ажиллагаа нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагын хүрээнд байх ёстой. Мэргэжлийн цар хүрээнээсээ хальж ажилладаг нийгмийн ажилтнууд ч бас байдаг бөгөөд тэд хүний тулгамдсан асуудал, өөрчлөлтөд өөрөөр хандах байдал ажиглагддаг.

2. Нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагаандаа өөрийгөө ухамсартайгаар ашиглах хэрэгтэй.

Нийгмийн ажлын практикт үйл ажиллагааны гол “багаж хэрэгсэл” нь нийгмийн ажилтан - өөрөө байдаг. Чадварлаг нийгмийн ажилтан бусадтай харилцаа тогтоож, хамтран ажиллахдаа өөрийн хувийн онцлог шинж, зан төрхдөө тулгуурладаг. Нийгмийн ажлын практикт нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэйгээ сайн харилцаатай байж үргэлж дэмжин урамшуулах нь мэргэжлийн тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх үндсэн нөхцөл болно.

Мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа нийгмийн ажилтан өөрийн хувийн үнэт зүйл, үзэл бодол, чиг хандлага, хүсэл сонирхол, итгэл үнэмшлээ шууд ба шууд бусаар, хэл яриа болон зан үйлээрээ байнга илэрхийлж байдаг. Иймд нийгмийн ажилтнууд өөрсдийн үнэт зүйл, итгэл үнэмшил, зан үйл нь мэргэжлийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг ухамсарлаж ойлгох хэрэгтэй. Мөн нийгмийн ажилтан өөрийн хувийн онцлог, бодгаль шинж чанараа сайн мэдэж байхын зэрэгцээ өөрийн амьдралд тулгарч буй аливаа саад бэрхшээл, тулгамдсан асуудалд тэвдэж сандралгүй, бодитой хандаж сурах шаардлагатай.

3. Нийгмийн ажилтан нь аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандах хэрэгтэй.

Цаг хугацаа өнгөрөх тусам хүмүүс тулгамдсан асуудлаа шийдвэрлэхийн тулд мэргэжлийн түвшинд тусламж, дэмжлэг үзүүлэгчдэд хандах болжээ. Мэргэжлийн түвшний иймэрхүү үйлчилгээ бий болж, хүмүүсийн хэрэглээ болохоос өмнө тэд өөрсдийн хүндрэл бэрхшээлтэй нөхцөл байдлаа бие даан эсвэл гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүсээс тусламж дэмжлэг хайх зэрэг аль болох өөрсдөө шийдвэрлэхийг оролдсоор ирсэн байна. Энэхүү хүчин чармайлт нь хэт их санаа зовж сэтгэлээр

унаснаас, мөн бусад хүмүүсийн хоорондоо зөрчилтэй зөвлөгөө, зааврын улмаас ихэнхдээ талаар болж бүтэлгүйтдэг ажээ.

Мэргэжилтнүүд тусламж үзүүлэх үйл явцдаа тодорхой түвшинг баримтлан ажиллах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчтэй ажиллахдаа тэнцвэртэй байдлыг хадгална гэсэн үг. Тухайлбал, үйлчлүүлэгчийн ашиг сонирхол, сэтгэл зовнилд хэт автсан нийгмийн ажилтан өөрсдийн мэргэжлийн үнэт зүйл, зорилгоо умартах явдал гардаг. Нөгөө талаас нь авч үзвэл, хэт өөрийнхөөрөө ханддаг, бусдын санаа бодол, үгийг үл тоомсорлодог нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид тусламж дэмжлэг үзүүлэхээсээ харин ч өөрчлөлт хийх урам зоригийг нь улам мохоож тээнэгэлзүүлэх нь бий. Иймд нийгмийн ажилтнууд сэтгэлийн хөдөлгөөнөө хянаж, зохицуулж чадсанаар тэнцвэртэй байдлыг хадгалж чадна.

Мэргэжлийн зорилгоо зөв тодорхойлох нь нийгмийн ажилтны өөрийнх нь сэтгэцийн эрүүл мэндэд маш чухал. Энэ нь мөн үйлчлүүлэгчийн болон нийгмийн тулгамдсан асуудалд хэрхэн хандах, өөрийнхөө хувийн амьдралын болон мэргэжлийн зүйлсээ ялгаж салгаж чаддаг байхад тусална. Түүнчлэн мэргэжлийн зорилгоо тодорхойлох нь ажлаас үүдэлтэй стрессээс сэргийлэхэд тустай.

4. Хүмүүс хоорондын ялгаатай байдлыг нийгмийн ажилтан хүндэтгэж үзэх ёстой.

Нийгмийн ажлын үйлчлүүлэгчид янз бүрийн хэл, соёл, шашин бүхий өөр өөр үндэс угсаа, үзэл бодолтой, түүнчлэн бие махбод ба оюун ухааны чадвараараа ч харилцан адилгүй хүмүүс байдаг. Түүнчлэн гаргаж буй зан үйл, аливаа үйдлийг гүйцэтгэх чадвараараа ч ялгаатай. Иймд нийгмийн ажилтан хүмүүс хоорондын иймэрхүү ялгаатай буюу онцлог байдлыг ойлгож, үүнд хүлээцтэй бөгөөд хүндэтгэлтэй хандаж сурах шаардлагатай.

Хэн нэгэнд этгээд, гаж санагдсан зан үйл, үйлдэл нь тухайн орчин нөхцөл, амьдралын хэв маяг, тухайн орны соёлд хэвийн зан үйлд тооцогдох нь бий. Иймд аль нэг соёл, олон нийтийн хэмжүүрээр бусдын зан үйл, хандлагыг шүүн дүгнэж, үнэлж болохгүй. Харин ч хүмүүс хоорондын ялгаатай байдал нь бидэнд амьдрал хичнээн баялаг болохыг харуулдаг. Хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгохгүй, хүлээн зөвшөөрөхгүй байх нь мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх бидний практикт саад бэрхшээл учруулдаг юм.

Нийгмийн ажилтан хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгон, түүнд хүндэтгэлтэй хандана гэдэг нь бас нийгмийн янз бүрийн бүлгүүд төдийгүй нэгэн ижил бүлэгт харьяалагдаж буй хувь хүмүүс хүртэл харилцан адилгүй өөр өөр туршлага хуримтлуулдгийг бодолцон иймэрхүү асуудалд мэдрэмжтэй хандахыг сануулсан үг юм. Иймд аливаа хүнийг харьяалагдаж буй хүн ам, бүлгийг нь үндэслэн түүний үнэт зүйл, итгэл үнэмшил, соёлын түвшний талаар урьдчилсан дүгнэлт хийж, түүндээ баригдахаас зайлсхийвэл зохино.

5. Нийгмийн ажилтан хувь хүнийхээ хувьд болон мэргэжлийнхээ хувьд байнга хөгжиж байх ёстой.

Нийгмийн ажилтан нийгэм, эдийн засаг, байгаль цаг уур, шилжилт хөдөлгөөн гэх мэтээр байнга хувьсан өөрчлөгдөж байдаг орчинд амьдарч буй хүмүүстэй ажиллахдаа “энд – ба – одоо” гэсэн зарчмыг баримталдаг. Дэмжлэг тусалцаа хэрэгтэй байгаа хүмүүст үйлчилгээ үзүүлэхэд тэдний хүрээлэн буй орчинтой илүү идэвхтэй харилцах шаардлагатай болно. Амьдралын олон янз асуудлын талаар тодорхой ойлголтгүй байж, хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулах нь нийгмийн ажилтны хувьд “ялзрах”-ын үүд болдог. Өөрөөр хэлбэл, янз бүрийн үйлчлүүлэгчтэй ажиллахдаа дан ганц арга барилаар цаг ямагт хандана гэж байхгүй. Нийгмийн ажилтан хувь хүнийхээ хувьд болон мэргэжлийнхээ хувьд байнга өсөж хөгжих боломжийг тасралтгүй эрэлхийлдэг байвал зохино.

Мэргэжлийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд байнгын шинэчлэл хэрэгтэй. Шинэ ойлголт хандлага, онол, үйлчилгээ үзүүлэх арга барил зэрэг нь мэргэжлийн холбогдолтой хурал, зөвлөгөөн, ажлын хэсгийн уулзалт болон ном зохиол дээр бичигдсэн байдаг. Мэргэжлийн холбогдолтой шинэ соргог мэдээ мэдээллийг цаг алдагдалгүй олж авч байх ёстой. Мэргэжлийн хил хязгаараас давсан өөр бусад үйл ажиллагаа болон дадлага туршлагад хэт автаж буй нийгмийн ажлын салбарын ажилтан бусдад тус нэмэр хүргэх нь хязгаарлагдмал болдог. Хүний нөхцөл байдал хэмжээлшгүй олон янз

байдаг гэдгийг хүлээн зөвшөөрч хүндэтгэх хэрэгтэй, мөн амьдралыг маш олон өнцгөөс харж ойлгохыг хичээх хэрэгтэй юм. Бодит үйл явдал, ном зохиол, шинжлэх ухаан, урлаг зэргээс гарч ирсэн үзэл санаануудыг тунгаан бодохын зэрэгцээ маш олон янзын хүмүүстэй харилцах нь нийгмийн ажилтны тасралтгүй үргэлжлэх хөгжлийн амин чухал зүйл юм.

6. Нийгмийн ажилтан бусдад хор хөнөөл учруулахуйц зүйлийг хийх ёсгүй.

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн амьдралыг эерэгээр өөрчлөхийн төлөө ажилладаг. Гэвч аливаа өөрчлөлт нь үргэлж ямарваа нэгэн эрсдлийг дагуулж байдаг тул нийгмийн ажилтан өөрчлөлтийг хийсний төлөө үйлчлүүлэгч ба түүний орчин тойронд учирч болох аливаа эрсдлийг урьдчилан харж, түүнийг даван туулах нөөц төлөвлөгөө, арга замыг боловсруулах шаардлагатай. Мөн нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн амьдрал, үйл ажиллагаанд өөрчлөлт бий болгох явцад тэдэнд учирч болох аливаа гэмтэл, хор хөнөөлийг аль болох бага хэмжээнд байлгах үүрэгтэй.

Нийгмийн ажилтны өөрчлөлт хийхийн төлөө дэвшүүлж буй зорилго, үйл ажиллагаа нь хувь хүн, гэр бүл, байгууллага, айл хөрш олон нийтийн эрүүл зан үйл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц байж болохгүй. Цаашилбал, шударга бус нөхцөл, шударга бус бодлого, шийдвэрийг өөрчлөхөөр тэмцэж байгаа нийгмийн ажилтан бусдад хор хөнөөл учруулахуйц арга барилыг хэрэглэхээс сэрэмжилвэл зохино. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажилтан бусдад дарамт шахалт үзүүлэхийг эсэргүүцэж, түүнтэй тэмцэн, өөрөө ч мөн адил шударга бус зан үйл гаргалгүйгээр шударга бус явдалтай тэмцэх ёстой юм.

7. Нийгмийн ажилтан үнэн зөв мэдлэг дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулах ёстой.

Аливаа мэргэжлийн хүмүүст итгэх нийгмийн итгэл үнэмшлийн гол цөм нь тухайн салбарын мэргэжилтнүүд хамгийн сүүлийн үеийн, хамгийн тохиромжтой мэдлэг, чадварыг ашиглан хүмүүст үйлчилнэ гэсэн хүлээлт, итгэл найдвар байдаг. Нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын практикт шинээр гарч ирж буй бүхий л мэдлэгийн түвшинтэй тэр бүр хөл нийлүүлэн зэрэгцэн явах боломжгүй. Гэсэн хэдий ч, нийгмийн ажилтан нь өөрийн гүйцэтгэдэг үйл ажиллагаатай шууд холбоотой хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллээс хоцролгүй, холбогдох салбартаа шаардлагатай мэдлэгийг хэрхэн олж авахаа мэддэг байвал зохино.

Нийгмийн ажлын практикт удаан хугацаагаар ажилласан мэргэжилтнүүдийн хувьд тэдний мэдлэгийн зарим нь өөрсдийнх нь амьдралын туршлагаас урган гарсан байдаг. Мэргэжлийн ном сурах бичиг, сэтгүүлийг тогтмол унших, мэргэжлийн хурал уулзалтуудад оролцох, байгууллагын ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах зэргээр нийгмийн ажилтнууд мэдлэгээ өргөжүүлж, тасралтгүй хөгжих боломжтой.

Электрон хэрэгслээр дамжуулан авсан болон хурал уулзалт, ном зохиолд бичигдсэн зүйлсийг нийгмийн ажилтнууд авч ашиглахдаа маш болгоомжтой хандах хэрэгтэй. Энэ бүхний ард буруу мэдээлэл дээр үндэслэн нөхцөл байдалд үнэлгээ өгч, үйл ажиллагааны шийдвэр гаргавал үйлчлүүлэгч эрсдэлтэй байдалд орж болзошгүй юм. Нийгмийн ажилтан бүр өөрийн практик үйл ажиллагаандаа онол болон үйлчилгээг үзүүлэх арга техникийг ашиглахаасаа өмнө шүүн тунгааж үздэг байх ёстой.

8. Нийгмийн ажилтан мэргэжлийн үнэт зүйлд баримжаалан, ёс зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой.

Практикийн ихэнх нөхцөл байдлын гол цөм нь үнэт зүйлстэй холбоотой асуудал байдаг. Нийгмийн ажилтнаас тусламж хүсэхээр ирсэн үйлчлүүлэгчийн өмнө тулгамдаж буй асуудал нь хүмүүс хоорондын эсвэл түүний амьдарч буй орчин дахь бусад хүмүүс, бүлэг, байгууллагын хоорондын үнэт зүйлийн зөрүүтэй байдлаас урган гарах нь бий. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчийн зан үйл, шийдвэрт түүний үнэт зүйл хүчтэй нөлөө үзүүлж байдгийг бодолцон тэдэнд туслахаар хичээхдээ тэдний үнэт зүйлсэд нийгмийн ажилтан мэдрэмжтэй хандаж ойлгохыг хичээх нь чухал.

Гэсэн хэдий ч ихэнх тохиолдолд хэрвээ үйлчлүүлэгч өөрийгөө болон өөрийнхөө амьдрал орчин нөхцлийг өөрчлөх гэж хичээж байгаа бол өөртэйгөө холбоотой бусад хүмүүсийн үнэт зүйлийг ойлгож хүлээн зөвшөөрч дасах шаардлагатай болдог. Үүнтэй адил нийгмийн ажилтан ч бусдад

тусалж чаддаг байхын тулд үйлчлүүлэгчийн үнэт зүйлсийг ойлгон хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Үйлчлүүлэгчтэй тулж ажиллаж байх үедээ нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн амьдрал, бодит байдлаас зайлшгүй урган гарч ирж буй түүний үнэт зүйлсэд мэдрэмжтэй хандвал зохино.

Ямар хүмүүст үйлчлэх, үйлчилгээг хэрхэн хүргэх тухай нийгмийн үйлчилгээний аливаа байгууллагын бодлого, шийдвэр нь тухайн байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгоос урган гардаг билээ. Иймд нийгмийн ажилтан аливаа байгууллагын хүрээнд ажиллахдаа аль эсвэл аль нэг газар, орон нутагт шинээр үйлчилгээний хэлбэр бий болгон нэвтрүүлэхдээ тухайн нөхцөл байдалд нөлөөлж болох бусдын үнэт зүйлсийг бодолцон үүнд мэдрэмжтэй хандахыг хичээх хэрэгтэй.

Нийгмийн ажилтнууд мөн өөрийн хувийн үнэт зүйл, итгэл үнэмшлийг сайтар ухамсарладаг байхын дээр үйлчлүүлэгчид өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ тулгахаас ямагт сэрэмжилж байвал зохино. Гэвч практик дахь нийгмийн ажилтны үйл ажиллагаа аливаа үнэт зүйлсээс ангид байж чаддаггүй. Заримдаа нийгмийн ажилтнууд хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг бодолцох юмуу эсвэл ганц нэг хүний эрх ашиг, сонирхлоос илүү нийгэм, олон нийтэд үзүүлэх үр нөлөөг тооцож шийдвэр гаргадаг. Практикт шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах нь нийгмийн ажилтнаас ёс зүйн хүрээнд олон зүйлийг бодож тунгаахыг шаарддаг.

9. Нийгмийн ажилтан хүнийг цогц байдлаар авч үзэх ёстой.

Ихэнх мэргэжил нь хүний аль нэг талыг л авч үздэг. Эмч нар гэхэд л голдуу бие бялдрын эрүүл мэндэд анхаардаг бол багш нар оюун ухааны хөгжилд, сэтгэл зүйчид хүний сэтгэлийн хөдөлгөөн, танин мэдэхүйн үйл явцыг авч үзэх жишээтэй. Харин нийгмийн ажил нь хүнийг биологи, сэтгэл зүй, нийгэм, оюун санаа гэх мэт бүхий л талаас нь цогцоор авч үздэг. Нийгмийн ажилтнуудын хувьд хүний зөвхөн нэг хэсэгтэй холбогдох практик үйл ажиллагаа гэж бараг л үгүй.

Хүнийг бүхэлд нь авч үзэхэд мөн тухайн хүний өнгөрсөн, одоо, ирээдүйн бүхий л асуудалд анхаарахыг шаарддаг. Энэ нь нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийн хойшлуулшгүй, эсвэл тулгараад байгаа асуудлын цаад талыг олж харах, хоол хүнсний дутагдал, орон байрны асуудлаас эхлээд амьдралын зорилго, утга учрыг үл ойлгох хүртэлх олон асуудлууд гарч ирнэ гэдэгт сэрэмжтэй байхыг шаарддаг. Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал болон үйлчлүүлэгчийн давуу тал хоёрт хоёуланд нь анхаарал хандуулах ёстой. Тэрээр үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал, түүний шалтгаан болж буй хүчин зүйлсийг тодруулах хэрэгтэй. “Хүнийг орчин нөхцөлд нь авч үзэх” гэсэн загварыг байнга санаж, нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн болон бусад хүмүүсийн сайн сайхан байдлыг авч үзнэ. Үйлчлүүлэгчийн зан үйл, нөхцөл байдал нь түүний ойр орчмын хүмүүст нөлөөлдөг учраас нийгмийн ажилтан үйл ажиллагаагаа явуулахдаа үүнийг ч бас бодолцох хэрэгтэй юм.

10. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн нэр хүндийг хамгаалах ёстой.

Аливаа хувь хүн ба бүлэг хүмүүс өөрсдийн нэр хүндээ хамгаалж, бусдын хүндэтгэлийг хүлээх зүй ёсны эрхтэй. Нийгмийн ажлын “Үйлчлүүлэгчийг байгаагаар нь хүлээн авах” зарчим нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид бусдын хүндэтгэл, халамжийг хүлээх ёстой тодорхой нэр хүнд бүхий хувь хүн гэдэг утгаар нь хандахыг хэлж буй хэрэг юм.

Үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэйгээр хандах нь нийгмийн ажилтнаас үйлчлүүлэгчид шүүмжлэлт байр сууринаас хандан ямарваа нэг үнэлэлт дүгнэлт хийхгүй байхыг шаарддаг. Нийгмийн ажилтны энэхүү шүүмжлэлт бус хандлага нь үйлчлүүлэгчид нийгэм, олон нийтийн зүгээс учруулдаг аливаа шүүмжлэлт хандлага, дарамт шахалтаас үүдэлтэй айдас түгшүүрээ даван туулах бололцоог олгож, улмаар тэдний хоорондын харилцааг эерэг уур амьсгалтай болгодог. Гэхдээ энэ нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн зүгээс гаргаж буй бүхий л зан үйлийг зөвтгөж сайшаана гэсэн үг биш юм. Заримдаа үйлчлүүлэгчийн гаргаж буй зан үйл, шийдвэр нь бусдад хор хөнөөл учруулж болохуйц байдаг. Энэ бүхнийг хүлээн зөвшөөрч зөвтгөлгүйгээр түүнийг тодорхой үнэ цэнэ, нэр хүнд бүхий хүн гэдэг утгаар нь хүндэтгэлтэй хандвал зохино.

11. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгч тус бүрийг өөр өөрийн гэсэн онцлогтой хувь хүн гэдэг байдлаар авч үзэх ёстой.

“Үйлчлүүлэгч хаана байна, тэндээс эхэл” гэсэн зарчим нийгмийн ажлын практикт байдаг. Нийгмийн ажилтан болохоор шийдэж, тус мэргэжлээр суралцах эхний өдрөөсөө л яг ижил хоёр хүн гэж хэзээ ч байдаггүй гэдгийг ухаарч, хүн тус бүрийг давтагдашгүй, онцлог хэмээн авч үзэн үйлчилгээ үзүүлэх ёстой. Энэ нь тухайн үйлчлүүлэгч юу бодож, юу мэдэрч байна, ямар тохиолдолд ямар зан авир гаргаж байна, нийгмийн ажлын үйлчилгээний үе шатуудад хэрхэн өөрчлөгдөж байна гэх мэт бүхий л зүйлд нэг бүрчлэн анхаарлаа хандуулах ёстой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажилтан нь үйлчилгээ үзүүлэхдээ хувь хүн (гэр бүл, бүлэг, олон нийт) тус бүрийг давтагдашгүй, онцлог шинж чанартай гэдгийг ямагт санаж, үүнийг үйл ажиллагаа бүртгээ санаж байх ёстой.

Энэхүү зарчим нь нийгмийн ажилтнуудыг үйлчлүүлэгч тус бүрийн бодит байдал, шинж чанар, нөхцөл байдалд мэдрэмжтэй хандахыг шаарддаг. Мөн түүнчлэн үйлчилгээний тодорхой үе шатуудад үйлчлүүлэгч тус бүрийн ялгаатай байдал, өөрчлөлт гарч буй цаг хугацаа, идэвх чармайлтыг хүндэтгэн үзэх хэрэгтэй. Нэг үйлчлүүлэгчид тохирч байсан арга барил нөгөө үйлчлүүлэгчид тохирохгүй ч байж болно. Бидний өгүүлж буй дээрх зарчим нь нийгмийн ажилтныг үйлчлүүлэгчтэй хэрхэн ажиллах, тэднээс юу хүсэн хүлээж байгаа зэрэгтээ уян хатан хандахыг хүсдэг.

12. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид итгэл найдвар төрүүлж, урам зоригийг нь сэргээж байх хэрэгтэй.

Үйлчлүүлэгчид үзүүлж буй аливаа тусламж, үйлчилгээ мэргэжлийн түвшинд байхын гол утга учир нь тухайн асуудалт нөхцөл байдалд шинэ үзэл санаа, шинэ хандлага, илүү үр дүнтэй арга барилаар ханддагт оршдог. Тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж байхад ямар нэгэн хүн, бүлгийн зүгээс тухайн асуудлыг шийдвэрлэх нь бүтэшгүй аль эсвэл их хэмжээний хөрөнгө мөнгө, хүн хүч, цаг хугацаа шаардагдах талаар хэлж хүмүүсийн урам зоригийг мохоох явдал тохиолддог. Энэ үед нийгмийн ажилтан хүмүүст тэдний хүсэж буй өөрчлөлтийг хийх боломжтой бөгөөд тухайн нөхцлийг даван туулах шинэ бөгөөд илүү сайн арга зам байдаг талаар ойлгуулж, тэдэнд итгэл үнэмшил, сэдэл тэмүүлэл бий болгох хэрэгтэй байдаг. Хэрвээ нийгмийн ажилтан өөрийн үйлчлүүлэгчдээ итгэл үнэмшлийг бодитойгоор төрүүлж, аливаа бэрхшээлийг даван туулахад түүнд байгаа авьяас чадвар, давуу талыг тодорхойлон, түүний ойрын хүрээллээс нөөц боломжийг олж илрүүлсэн тохиолдолд үйлчлүүлэгч цаашдынхаа амьдрал, үйл ажиллагаанд илүү итгэл найдвартай хандаж, нийгмийн ажилтантай илүү нээлттэй илэн далангүй харьцах болдог.

Эерэг өөрчлөлт бий болгохын төлөө аливаад шинэ үзэл санаа, арга барилаар хандаж байгаа тохиолдолд нийгмийн ажилтан түүний давуу ба хязгаарлагдмал талд бодитой бөгөөд шударга хандах ёстой юм. Үйлчлүүлэгчид худлаа итгэл үнэмшил төрүүлэх буюу бодитой биш үр дагавраас хамгаалах нь тэдэнд тусалж байгаа хэрэг биш билээ.

13. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн давуу тал дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулна.

Нийгмийн ажилтнууд болон хүмүүст үйлчилдэг бусад мэргэжилтнүүд үйлчлүүлэгчийн асуудлаас өөр зүйл бодохоо больж, үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, тэдний хязгаарлагдмал болон сул талыг тодорхойлоход нэлээдгүй цаг хүчээ зарцуулдаг. Нийгмийн ажилтнуудын хувьд үйлчлүүлэгчид туслах, түүнийг өөрчлөхөд хамгийн чухал зүйл бол үйлчлүүлэгчийн өөрийнх нь нөөц, чадвар боломж юм. Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн хяналт чухлаар тавигдах болсноос хойш нийгмийн ажлын практикт үйлчлүүлэгчийн өөрсдийнх нь хүч чадал, давуу талыг олж илрүүлэн, ашиглахад туслах нь хамгийн чухал зүйл болсон. Үйлчлүүлэгчийн давуу талд тулгуурлах түүнийг чухалчлан авч үзэх нь зөвхөн тулгамдсан асуудал, эмгэг байдалд анхаарахаас илүү үр дүнтэй.

14. Нийгмийн ажилтан асуудал шийдвэрлэх үйл явцад үйлчлүүлэгчийг аль болох бүрэн дүүрэн оролцуулахыг хичээнэ.

“Өөртөө туслахад нь үйлчлүүлэгчид туслах” зарчим нь дараах үзэл санаан дээр тулгуурладаг. Аливаа өөрчлөлт, хөгжлийн эцсийн үр шимийг хүртэх хүмүүс өөрчлөлтийг бий болгох үйл явцад биечлэн оролцож байж энэ бүхний үнэ цэнийг мэдрэн, улмаар бий болгосон нөхцөл байдлаа тогтвортой хадгалах, улам сайжруулах чин хүсэл эрмэлзэлтэй болдог.

Асуудлыг шийдвэрлэх үйл явцад үйлчлүүлэгчийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд нийгмийн ажилтан “үйлчлүүлэгчийнхээ өмнөөс өөрөө хийх биш хамтдаа хийх” зарчмыг баримтлах ёстой. Жишээлбэл үйлчлүүлэгчийн өмнө тулгамдаж буй асуудлын талаар нийгмийн ажилтны гаргасан нарийн оношилгоо дүгнэлт хэрвээ үйлчлүүлэгч ойлгож, хүлээн зөвшөөрч чадахгүй бол үүнийг хэрэгжинэ гэж үзэхэд бэрхшээлтэй. Үйлчлүүлэгч өөрчлөлт хийх хэрэгцээ, шаардлагыг бүрэн ухаарч, улмаар өөрчлөлтийг хийхийн төлөө аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд бэлэн байгаа цагт сая өөрчлөлтийг эхлүүлэхэд амжилттай болно. Үүнтэй адил үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа ч үйлчлүүлэгчийг орхигдуулж болохгүй. Өвчтөндөө эм тариа өгөх, хагалгаа хийх байдлаар өвчнийг эмчилдэг эмч, эсвэл үйлчлүүлэгчийнхээ өмнөөс ганцаараа зүтгэдэг өмгөөлөгчөөс ялгаатай нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийнхээ хамтран зүтгэгч, дэмжин идэвхжүүлэгч нь байдаг. Хэдийгээр нийгмийн ажилтан үйлчлүүлэгчээ өмгөөлөн түүний өмнөөс ажиллах шаардлага тулгардаг боловч үйлчлүүлэгчийн оролцоог аль болох их байлгахад анхаарах хэрэгтэй.

15. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн өөрийгөө тодорхойлох чадварыг дэмжих ёстой.

Нийгмийн ажлын практикт “Үйлчлүүлэгчийг биш, үйл явцыг чиглүүл” гэсэн бас нэгэн чухал зарчим байдаг. Энэ зарчим нь ямар нэг шийдвэр гаргаж, түүний дагуу амьдарч буй хүн тухайн шийдвэрээ өөрөө гаргах эрх чөлөөтэй байх ёстой гэсэн үзэл санаан дээр суурилсан үг юм. Нийгмийн ажилтнууд нь үйлчлүүлэгчдэд янз бүрийн үзэл санаа, юмыг олон талаас нь авч үзэх, шинэ зүйлийг эрэлхийлэхэд туслах ёстой. Харин хамгийн эцсийн шийдвэрийг гаргахад зааварлаж чиглүүлэх ёсгүй.

Өөрийгөө тодорхойлох зарчим нь үйлчлүүлэгчид өөрт нь авъяас, чадвар боломж байдаг бөгөөд тэд бусадтай харилцах харилцаа холбоо, хийх гэж буй үйлдэлдээ шийдвэр гаргах хууль эрх зүйн бүрэн чадамжтай гэж үздэг. Зарим тохиолдолд энэ таамаглал нь үнэн зөв байдаггүй. Зарим үйлчлүүлэгчдийн хувьд ямар нэг үйлдлийн үр дагаврыг ойлгохгүй байх, эсвэл магадгүй шүүн тунгаах, дүгнэж цэгнэж бодох чадваргүй буюу сэтгэцийн эмгэгтэй байх бөгөөд тэд өөртөө болон бусдад хор хохирол учруулахуйц ч шийдвэр гаргаж болох юм. Ийм нөхцөлд нийгмийн ажилтнууд нь тэдний өмнөөс шийдвэр гаргах үүргийг хариуцдаг.

Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн өмнөөс шийдвэр гаргах хариуцлагыг хүссэн хүсээгүй ч үүрэх бөгөөд харин нөхцөл байдлыг маш сайн судалж үзэн, мэргэжил нэгтнүүд болон холбогдох бусад хүмүүстэй зөвлөлдөх нь тэдэнд тус болно. Аль болох боломжоороо үйлчлүүлэгчийг өөрөөр нь шийдвэр гаргуулах ёстой. Өөрсдийнхөө хувь заяаг өөрсдөө тодорхойлох үйлчлүүлэгчийн боломж, чадварыг дээшлүүлэхийг оролдох нь нийгмийн ажилтны үүрэг билээ.

16. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийг тулгамдаж буй асуудлаа өөрийн хүчээр шийдвэрлэх үр чадвараа хөгжүүлэхэд нь туслах ёстой.

Ихэнх нийгмийн ажилтнууд “хүмүүсийг өөртөө туслахад нь туслах ёстой” гэсэн үзэл санааг баримталдаг. Үүнийг “хүмүүст одоо ба ирээдүйд ч өөртөө туслахад нь туслах” гэсэн утгаар тайлбарлаж болно.

Бидний олонх нь биеийн илүүдэл жиндээ байнга л санаа зовж, хэрхэн жингээ хасах талаар бусдаас туршлага судалж, идэвхтэй оролдлого хийсний үндсэн дээр овоо хэдэн кг хасч тодорхой амжилтанд хүрдэг боловч хэсэг хугацааны дараа хассан жингээ эргэн нөхчихөөд харамсаж суух нь тохиолддог. Үүнтэй ижил, мэргэжлийн хүний туслалцаа дэмжлэгтэйгээр үйлчлүүлэгчийн амьдралд бий болсон аливаа эерэг өөрчлөлт хэрвээ үйлчлүүлэгчийг бий болсон тухайн нөхцлийг тогтвортой хадгалахад бэлтгээгүй тохиолдолд эргээд хуучин хэвэндээ орох эсвэл хуучнаасаа дордох нь бий.

Өөрөөр хэлбэл бий болгосон өөрчлөлт ба үйлчилгээний үр дүнг тогтвортой хадгалж, үр шимийг хүртэж чадах эсэх нь үйлчлүүлэгч буюу хэрэглэгчээс шууд хамаарч байдаг билээ. Иймд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийг цаашдын амьдралд тохиолдож болох ямарваа хүндрэл бэрхшээлийг даван туулах ур чадварт сургаж, тухайн нөхцөлд өөрийгөө дайчлан амьдралынхаа төлөө идэвхтэй тэмцэх сэтгэл зүйг төлөвшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Үйлчлүүлэгч өөрийнхөө асуудлыг шийдвэрлэх, даван туулахын тулд нийгмийн ажилтантай хамт байх хугацаандаа тухайн үед болон ирээдүйд тохиолдож болох олон асуудалд санаа зовж байгаагаа илэрхийлж, энэ бүхэнд нийгмийн ажилтнаас тусламж хүсэж болох юм. Энэ үед “Үйлчлүүлэгчийн өөрийнхөө төлөө хийж чадах зүйлийг түүний өмнөөс бүү хий” гэсэн зүйр үгийг санаж цаашдын амьдралаа өөрөө аваад явах чадвар, сэтгэл зүй төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой юм. Мөн үйлчлүүлэгчийг цаашдын амьдралд бэлтгэхийн чухал тал нь түүнийг өөрийн ойрын хүрээлэл, орчин тойронд байгаа нөөц боломжийг олж харж, ашиглаж сурахад бэлтгэх явдал байдаг.

17. Нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийг чадваржуулах ёстой.

Нийгмийн ажилтнууд нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхэнд үйлчилдэг бөгөөд тэд ялгаварлан гадуурхагдаж, хүчирхийлэлд өртсөн гэх мэт маш олон төрлийн асуудалтай байх нь бий. Үйлчлүүлэгчийнхээ нийгмийн үйл ажиллагаанд нь хувь нэмрээ оруулах, тэдэнд туслах нэгэн арга зам бол үйлчлүүлэгчээ чадваржуулах явдал юм.

Үйлчлүүлэгчийн оролцоог сайжруулах, үйлчлүүлэгчийн өөрийгөө тодорхойлох чадварыг сайжруулах, асуудал шийдвэрлэх ур чадварыг хөгжүүлэх гэх мэт үйлчлүүлэгчдийн амьдралын олон асуудалд хяналт тавихад үр дүнтэй олон зарчмууд байгаагийн зэрэгцээ үйлчлүүлэгчийг чадваржуулах зарчим нь бас нэгэн чухал зүйл юм.

Нийгмийн ажил үүсэж хөгжсөн цагаас эхлээд нийгмийн ажлын философид амьдралын аливаа асуудлыг давж гарахад нь хүмүүст туслах гол арга зам бол хувь хүн, хамт олныг чадваржуулах явдал байсан.

Нийгмийн ажилтнуудын хувьд үйлчлүүлэгчдээ чадваржуулах арга замыг олох нь нэлээд төвөгтэй асуудал юм. Учир нь мэргэжлийн дадлага туршлага дээр суурилсан олон төрлийн практик загварууд байдаг ч тэдгээр нь үйлчлүүлэгчдэд тохирох тохирохгүй янз бүр байна. Үйлчлүүлэгчээ чадваржуулснаар хувь хүмүүс болон гэр бүлд өөрсдийн амьдралаа авч явах, хийж буй үйлдэлдээ эзэн болоход нь нийгмийн ажилтан тусалж чадна.

18. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах ёстой.

Нийгмийн ажилтнаас тусламж хүсэн ирж буй хувь хүн, гэр бүл ихэвчлэн өөрсдийнхөө хувийн дотоод амьдралын талаарх нарийн ширийн зүйлсийг дэлгэн ярих хандлагатай байдаг. Түүнчлэн бүлэгтэй ажиллаж байх явцад ч хувь хүн өөрийн хувийн нууц, дотоод мэдрэмжээ бүлгийн гишүүддээ задлах нь бий. Мэргэжлийн практикт үйлчлүүлэгчийн итгэн задалсан нууц мэдээлэл нь үйлчлүүлэгчийн нэр хүнд, байр суурь, ирээдүйн амьдралтай нь шууд холбоотой байдаг тул нийгмийн ажилтнаас тухайн мэдээллийг ашиглах, хадгалахдаа тун болгоомжтой хандахыг шаарддаг.

Практикт үйлчлүүлэгчийнхээ нууцлалыг хадгалах туйлын ба харьцангуй гэсэн үндсэн 2 түвшин байдаг. Туйлын нууцлал нь үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг ямар ч нөхцөлд хэнд ч мэдээлж задлахгүй байх нөхцөл юм. Хувь хүний нууцыг энэ түвшинд хадгалах нь хэцүү байдаг. Энэ нь үйлчлүүлэгч давуу эрхээрээ хууль, эрх зүйн хүрээнд өөрийн нууцлалаа хангахыг шаардсан ба түүнийг нь мэргэжлийн байгууллага зөвшөөрч баталгаажуулсан нөхцөлд хийгддэг. Нийгмийн ажлын практикт ихэвчлэн үйлчлүүлэгчийн нууцыг харьцангуй түвшинд хадгалдаг. Энэ нь үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг мэргэжлийн ёс зүйн кодекс, хувь хүний нууцын тухай холбогдох хууль тогтоомж, байгууллагын бодлого, дүрэм журмын хүрээнд хадгалж, мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах нөхцөл юм. Үйлчлүүлэгчтэй ажиллахдаа нууцлалыг ямар түвшинд хадгалах нь тухайн мэдээллийн шинж чанар, байгууллагын бодлого, мөн чанар, баримтлах хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээнээс шалтгаалж харилцан адилгүй байдаг.

Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалахын тулд нийгмийн ажилтан ярилцлага хийх газраа хүртэл сайн төлөвлөн бэлтгэж мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтын үед үйлчлүүлэгчийнхээ талаарх асуудлыг хэлэлцүүлэхдээ ямар мэдээлэл хүргэхээ сонгох зэрэгт ч маш болгоомжтой хандах шаардлагатай болдог. Цаашилбал хүний хувийн амьдрал ба ажил төрлийн талаарх мэдээллийг ялгаж салгаж байх нь түүний гэр бүл, найз нөхөдтэй харилцах үед үйлчлүүлэгчийн нууцын талаар “ам алдаж болзошгүй” аюулаас зайлсхийхэд чухал байдаг.

19. Нийгмийн ажилтан хүнийг хэвийн гэсэн үзэл хандлагыг баримталж ажиллавал зохино.

Нийгмийн ажлын олон үйлчлүүлэгч сэтгэцийн болоод бие бялдрын хувьд хөгжлийн бэрхшээлтэй байдаг. Ийнхүү ямар нэгэн сул, хязгаарлагдмал талаасаа болоод тэд ихэнхдээ нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөж тусгаарлагддаг. Бусадтай адил жирийн гэж хандах үзэл баримтлал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтийн амьдралд хөл нийлүүлэн амьдрах, тодорхой хэмжээгээр тэдний амьдрал жирийн хүмүүсийнхтэй адил, ижил төстэй гэдгийг ойлгуулж дэмжихэд томоохон дэмжлэг болдог. Энэ философи нь оюуны хомсдолтой хүмүүсийн асуудлаас анх гарч ирсэн боловч одоо өндөр настан, бие бялдрын согогтой, сэтгэцийн эмгэгтэй гэх мэт бусад бүлгийн хүмүүст үйлчилгээ үзүүлдэг хөтөлбөрүүдэд ч бас хэрэглэгддэг.

Хэвийн хэмжээ буюу норматив гэдэг ухагдахуун нь ердийн жирийн гэсэн утгыг агуулна. Тухайлбал, оюуны хомсдолтой хүн аль болох боломжийн хэрээр бусдын адил жирийн гэр оронд, жирийн нөхцөлд амьдрах ёстой. Мөн түүнчлэн тэд бусдын адил амралт, чөлөөт цагтай байх, өөрийн гэсэн шашин шүтлэг, сүсэг бишрэлтэй байх, бусадтай адил хувцаслаж, олон нийтийн тээврийн хэрэгслийг ашиглаж, өдөр тутмын үйл ажиллагаа нь ч гэсэн аль болохоор ердийн байх ёстой. Үүнтэй адилаар тэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн бусад үйлчилгээг жирийн хүмүүс хаанаас авдаг тэр л албан эх сурвалжуудаас авах боломжтой байх ёстой.

Хэвийн хэмжээнд авч үзэх үзэл баримтлалын онолын үндэс нь суралцахуйн онолоос ялангуяа, бусдыг даган дууриах, үлгэр дууриал, загвар авах гэсэн санаанаас гарч ирсэн. Энэ философи нь хүнийг бие бялдрын болон сэтгэцийн эмгэгтэй талаас нь харах биш, харин хүн гэдэг үүднээс авч үзэхийг ойлгуулдаг.

20. Нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагааны явцад гарч буй аливаа өсөлт өөрчлөлт, хөгжил дэвшлийг тогтмол үнэлж байх хэрэгтэй.

Нийгмийн ажлын практик нь нарийн тогтсон шинжлэх ухаанаас ялгаатай. Энэ нь байнга өөрчлөгдөж байдаг нөхцөл байдалд үргэлж өөрчлөгдөж байдаг хүмүүстэй ажилладаг. Иймд тусламж, үйлчилгээний зорилго нь үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтмол үнэлж дүгнэж байх хэрэгтэй.

Нийгмийн ажлын практикт аливаа үйлчилгээ тусламжийг төлөвлөөд улмаар түүнээс гарах үр дүнг урьдчилан тооцоолоод орхих нь хангалттай биш юм. Үйл ажиллагаа хэрэгжих явцад үйлчлүүлэгч ба нийгмийн ажилтан аль аль нь бий болж буй өөрчлөлтөнд тогтмол хяналт тавин, үнэлэн дүгнэж байх нь чухал юм. Үүнийг хийхийн тулд нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч аль аль нь өөрчлөлтийг харуулах холбогдох мэдээ, баримтыг цуглуулж, тэмдэглэж, тэдгээрт анхааралтайгаар дүн шинжилгээ хийж байх хэрэгтэй. Хэрвээ хүсэж байгаа өөрчлөлтийг бий болгож чадаагүй бол нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дахин боловсруулж, өөр хандлага, арга зүйг дахин хэрэгжүүлэхээр оролдох үүрэгтэй.

21. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгч, байгууллага, олон нийт болон нийгмийн ажлын мэргэжлийнхээ өмнө хариуцлага хүлээнэ.

Нийгмийн ажилтны үйл ажиллагааг төвөгтэй, хэцүү болгодог нэгэн хүчин зүйл бол нийгмийн ажилтан хамтран ажилладаг олон талуудын өмнө хариуцлага хүлээдэг явдал юм. Зарим зарчмын хувьд, нийгмийн ажилтан зөвхөн үйлчлүүлэгчийнхээ өмнө хариуцлагатай байх ёстой мэт боловч

Үнэн хэрэгтээ нийгмийн ажилтнууд хувь хүн, түүний харилцаж буй хүрээлэн буй орчинд ажиллаж, тэдгээрийн өмнө ч хариуцлага хүлээж байдаг.

Нийгмийн ажилтан нь ямар ч үйлчлүүлэгчид, шаардлагатай үед нь үйлчилгээг чанартай, сайн үзүүлэх үүрэгтэй бөгөө шууд үйлчилгээ үзүүлж буй тэдгээр хувь хүмүүс, гэр бүл, бүлгүүдийн өмнө хариуцлага хүлээх ёстой. Мөн бүх нийгмийн ажилтан ямарваа нэг үйлчилгээний байгууллагад харьяалагдан ажиллах бөгөөд тэд тухайн байгууллагынхаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй хөтөлбөрийн өмнөөс мөн хариуцлага хүлээнэ. Байгууллагын өмнөөс хариуцлага хүлээнэ гэдэг нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа хэрэглэгчдийн өмнө хариуцлага хүлээнэ гэсэн үг. Нийгмийн ажилтнууд байгууллагыг төлөөлөн үзүүлж буй үйлчилгээнийхээ чанараас шалтгаалан тус байгууллагын нэр хүнд, хөрөнгө санхүүжилт, амжилтад хариуцлага хүлээдэг.

Тухайн мэргэжил оршин тогтнох эсэх нь олон нийтийн өмнө тодорхой үүрэг хариуцлагатай байхыг мэргэжилтнүүдээсээ шаарддаг. Ихэнх нийгмийн ажилтнуудын хувьд энэ үүрэг хариуцлага нь лицензээр дамжин баталгааждаг. Нийгмийн ажлын ёс зүйн хэм хэмжээнд нийгмийн ажлын мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгчид, мэргэжил нэгт нөхөд, ажил олгогч, мэргэжил болон нийгийнхээ өмнө хариуцлага хүлээх ёстой гэж заасан байдаг.

Эх сурвалж:

Sheafor.B.W., Horejsi.C.R and Horejsi.C.A.*Techniques and Guidelines for Social Work Practice*. A Pearson education Company.2000